

# МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код: 65.020.40

Улиасны суулгац. Ерөнхий шаардлага	MNS 6257 : 2011
Poplar seedlings. General requirement	

Стандартчилал, Хэмжилзүйн Үндэсний Зөвлөлийн 2011 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 25 дугаар тогтоолоор батлав.

Энэ стандартыг улсын бүртгэлд бүртгэсэн өдрөөс эхлэн мөрдөнө.

## 1 Хамрах хүрээ

Энэхүү стандарт нь хот, суурин газрын нийтийн эзэмшил, хязгаарлагдмал хэрэгцээний болон тусгай зориулалтын ногоон байгууламжид тарих улиасны суулгацыг ухаж авах, хадгалах, тээвэрлэхэд хамаарна.

## 2 Норматив ишлэл

Энэхүү стандартад дараах баримт бичгийг иш татсан бөгөөд эдгээр стандартад өөрчлөлт орсон тохиолдолд хамгийн сүүлчийн албан ёсны материалаас иш татаж хэрэглэнэ.

- MNS 6141 : 2010, Навчит төрлийн модны суулгац. Техникийн шаардлага
- ГОСТ 17266:71, Улиасны суулгац. Техникийн шаардлага

## 3 Нэр томъёо, тодорхойлолт

### 3.1

#### Тайраадасны суулгац

Тайраадаснаас ургуулсан суулгац,

### 3.2

#### Таримал ой

Тарьц болон үр, мөчрөөс ургуулсан нэг, хоёр буюу хэд хэдэн төрөл зүйлийн ижил насны мод адил зайд ургасан таримал,

## 4 Ангилал

Улиасны суулгацыг ишний уртаар нь:

- I,
- II зэрэг гэж 2 ангилна.

## 5 Техникийн шаардлага

**5.1** Улиасны модожсон мөчрийн тайраадсаар ургуулсан суулгацыг мод үржүүлгийн газрын бойжуулгын талбайд 1-ээс 3 жил ургуулсан байна.

**5.2** Улиасны суулгац нь уртаараа дараах зэрэгт хуваагдана.

## Улиасны суулгац уртын хэмжээ, см-ээр

1-р хүснэгт

Улиасны суулгацны нас /жилээр/	Ойт хээрийн бүсэд		Хээрийн бүсэд	
	I зэрэг	II зэрэг	I зэрэг	II зэрэг
1	131-150	90-130	91-180	60-90
2	210-230	160-200	161-180	150-160
3	281-300	260-280	241-260	210-240

**5.3** Суулгацын үндэс нь үндэсний хүзүүнээс 20-оос 25 см-ээс доошгүй жигд тайрагдана.

**5.4** Үндсийг нь хэт ойртуулж тайрсан буюу сэмэлж цуулсан байвал хэдийгээр өндрийн хэмжээгээр стандартын зэрэгт таарч байсан ч түүний зэргийг бууруулна.

**5.5** Модожсон мөчрийн тайраадсаар үржүүлсэн улиасны суулгацны салаалсан үндэсний тоо 5-аас дээшгүй байвал мөн зэргийг нь бууруулж тогтооно.

**5.6** Суулгац нь эрүүл, хөгжилт сайтай, өвчин хортон, шавьжид нэрвэгдээгүй байна.

## 6. Суулгацыг ухаж авах, хадгалах, тээвэрлэх

**6.1** Стандартад заасан шаардлагад хүртэл ургасан суулгацыг үнэлгээ, тооллого явуулсаны дараа намар модны навч унаснаас хойш 9-өөс 10-р сард, хавар нахиа задрахаас өмнө 4-өөс 5-р сард ухаж авна.

Суулгацыг ухах үед үндэсний систем болон иш холтос, нахиаг гэмтээхийг хориглоно.

**6.2** Ухаж авсан суулгацыг стандартын шаардлагын дагуу зэрэглэж дугаарлана. зэрэг тогтоох ажлыг салхи, нарны нөлөөнөөс хамгаалагдсан сүүдэр, нөмөр газарт явуулна.

**6.3** Зэрэг тогтоолтоор стандартын шаардлага хангаагүй суулгацыг бойжуулгын талбайд дахин суулгаж ургуулна.

**6.4** Улиасны суулгацыг суулгах хүртлээ нэг тал нь налуу нөгөө тал нь эгц ирмэгтэй 40-өөс 60см гүн, 1м өргөн нүхэнд эгнүүлэн хийж, 30-аас 40 см зузаан шороогоор хучиж, жигд услаж, түр хадгална.

**6.5** Өвөл суулгац хадгалах газрыг тойруулан эгц ирмэгтэй 70 см өргөн, 60 см гүнзгий шуудуу ухаж мэрэгчдээс хамгаалж, энэ шуудууг цас орсны дараа цэвэрлэнэ.

**6.6** Хавар ухаж бэлтгэсэн тарьцыг цасны усанд автагдахааргүй өндөр газарт ухсан нүх юмуу шуудуунд түр хадгална. Урьдаас бэлтгэсэн цас байхгүй бол дээр нь сүүдрэвч саравч барьж өгнө.

**6.7** Улиасны суулгацыг тээвэрлэхдээ машины тэвшинд чийгтэй үртсийг 40-өөс 50см, үртэсгүй нөхцөлд бууц буюу шороог 25-аас 30 см дэвсэж, түүн дээр суулгацыг эгнээгээр налуулан тавиад, үндсийг дээрх материалаар хучин услаж тээвэрлэнэ. Тээвэрлэх хугацаанд тогтмол чийгтэй байлгана.

**6.8** Улиасны суулгацыг хаягжуулна. Үүнд:

- Суулгацыг үржүүлэгч байгууллагын нэр,
- Суулгацын нас,
- Зэрэг,
- Тоо зэргийг заасан хаяг зүүсэн байна.

**ТӨГСӨВ.**